



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 05 сарын 29 өдөр

Дугаар A/368

Булган сум

Эх баригч, лаборант, сувилагч нарт
дэмжлэг үзүүлэхэд хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны IV хуралдааны “Булган аймгийн 2025 оны төсөв батлах тухай” IV/26 дугаар тогтоол, 2025 оны VI дугаар хуралдааны “Эрүүл Булган хөтөлбөр батлах тухай” VI/32 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Олон улсын эх баригч, лаборант, сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтнүүдийн өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд зохион байгуулагдах “Бидний мэргэжил сайхан” ажил мэргэжлийн уралдаан, “Сувилагч судлаач-2025” онол, практикийн бага хурал зохион байгуулах зардалд 1,500,000 (нэг сая таван зуу мянга) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дэмжлэг үзүүлэхэд шаардагдах хөрөнгийг “Эрүүл Булган” хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас гаргахыг Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Б.Ариунболд)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР

